



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 4/19

Хэрлэнбаян-Улаан

Зардал гаргах тухай

Монгол Улсын “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1, 17 дугаар зүйлийн 17.3, “Төсвийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5, “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт хаваржилтад бэлтгэх, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг зарцуулсугай.

2. Өвөлжилт хаваржилтад бэлтгэх, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардалд гамшгийн эрсдлийн сангаас 1,000,000 (нэг сая) төгрөг, нөөц сангаас 2,000,000 (хоёр сая) төгрөг тус тус гаргахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (С.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Ж.МАРТ